1. Эдлэлийн хэсгийг огтолж, огтлолд үүссэн дүрсийг дурын байрлалд дүрслэн харуулах аргыг сонгоно уу.
   A. шилжүүлсэн огтлол
   B. дунд нь дүрслэх огтлол
   C. давхцуулсан огтлол
   D. дээр давхцуулах огтлол

2. Аливаа эдлэлийг зохион бүтээхдээ түүний хэлбэр, хэмжээ, өнгө, материал, чимэглэлийг тодорхой аргуудын тусламжтайгаар нэгтгэн нэгэн цогц болгосон шийдлийг сонгоно уу.
   A. дизайн
   B. загвар
   C. технологи
   D. зохиомж

3. Бүтээгдэхүүний хэлбэр хэмжээний зохион бүтээлтэд ашигладаг алтан харьцааг сонгоно уу.
   A. 1:2
   B. 1:1.5
   C. 1:1.618
   D. 1:3

4. Модон материалын огтлолыг дүрсэлсэн тэмдэглэгээг харуулсан зургийг сонгоно уу.



A. B. C. D.

5. Зурагт үзүүлсэн деталийг огтлогч B хавтгайгаар огтлоход үүсэх дүрсийг зөв дүрсэлсэн зургийг сонгоно уу.






A. B. C. D.

6. Зурагт үзүүлсэн деталийн ажлын зурагт сумаар заасан огтлолыг дүрсэлсэн аргыг сонгоно уу.



A. дурын зайд шилжүүлэх
B. проекц дээр давхцуулах
C. хавтгайн мөрийн дагуу шилжүүлэх
D. проекцыг таслан дундах зайд давхцуулах

7. Зурагт үзүүлсэн зүсэлтийн дүрслэлүүдийг нэршилтэй нь зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.




**1.** **2.** **3.**

**a.** нүүрний зүсэлт **b.** хажуугийн зүсэлт **c.** хэвтээ зүсэлт

A. 1-c, 2-b, 3-a B. 1-a, 2-b, 3-c C. 1-b, 2-a, 3-c D. 1-c, 2-a, 3-b

8. Тэгш өнцгийн проекцын хажуугийн проекцыг зөв дүрсэлсэн зургийг сонгоно уу.





A.


B.


C.


D.

9. Зурагт үзүүлсэн деталийн 1/4 зүсэлтийн тэгш өнцгийн проекцыг зөв дүрсэлсэн зургийг сонгоно уу.




A.


B.


C.


D.

10. Сийлбэр хийх модон материалыг сонгохдоо анхаарах гол физик шинж чанарыг сонгоно уу.

A. өнгө B. хээ зураглал C. гялалзалт D. нягт

11. Зөөлөн, нягт ширхэгтэй, хөнгөн, сийлбэр хийхэд нэн тохиромжтой шаргал цагаан өнгөтэй модыг сонгоно уу.

A. хуш B. нарс C. улиас D. шинэс

12. Сийлбэр хийх технологи үйл ажиллагааны үед баримтлах аюулгүй ажиллагааны дүрэмд **хамаарахгүй** хариуг сонгоно уу.

A. Сийлбэрийн багажаа зөв хадгалах.
B. Сийлбэрийн хутга хурц иртэй байх.
C. Сийлбэрийн хутгаар ажиллахдаа гараа зүсэхээс болгоомжлох.
D. Сийлбэрийн хутгыг ширээний ирмэг буланд тавихыг хориглоно.

13. Монгол дархны урлалыг хар болон өнгөт төмөрлөгийн гэж ангилдаг. Хар төмөрлөгийн төрөлд орох металлуудыг сонгоно уу.

A. алт, мөнгө B. зэс, цайр C. хүрэл, гууль D. болд, ширэм

14. Сийлбэрийн багажийг хэрэглэгдэх байдлаар нь үндсэн ба туслах багаж гэж ангилдаг. Үндсэн багаж болох ухам хутгыг харуулсан зургийг сонгоно уу.


A.


B.


C.


D.

15. Цоолбор сийлбэр хийхэд зайлшгүй шаардлагатай сийлбэрийн туслах гар багажийг сонгоно уу.


A.


B.


C.


D.

16. Модон сийлбэрийг ихэвчлэн гар багажаар хийдэг. Сийлбэрийн үндсэн багаж болох цүүц хэлбэрийн хутгаар зорох технологийг харуулсан зургийг сонгоно уу.


A.


B.


C.


D.

17. Модон сийлбэрийг ерөнхийд нь хавтгай, бүтэн гэж ангилах бөгөөд сийлбэрлэх технологи аргачлал нь өөр өөр байдаг. Хавтгай сийлбэрийн төрөлд хамаарах хагас товгор сийлбэрийг харуулсан зургийг сонгоно уу.


A.


B.


C.


D.

18. Монгол нутагт хүрэл зэвсэг хийж эхэлсэн үеэс эхлэн дархны урлал хөгжиж иржээ. Дархны урлалын үндсэн аргад хөөмөл, цутгуур, гагнуур, сийлбэр, өнгөлгөө зэрэг орно. Хөөмлийн аргаар хийсэн бүтээлийн зургийг сонгоно уу.


A.


B.


C.


D.

19. Хөөмлийг ямар багажаар хэрхэн урласнаар нь хавтгай ингэмэл хөөмөл, товгор хөөмөл, бүтэн хөөмөл гэж нэрлэдэг. Хөөмлийн дэвсгэр хэсгийг цоохорлох технологийг харуулсан зургийг сонгоно уу.


A.


B.


C.


D.

20. Сийлбэрийн хутгыг зөв барьж аюулгүй ажиллагааг баримтлан ажиллахдаа, модлогийн ширхгийг анхаарч, сийлбэрлэх зоролтыг гүйцэтгэдэг. Сийлбэрийн хутгыг зөв барьж ажиллах байдлыг жишээ зурагтай зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

| | | |
|---|---|---|
| **1.** Баруун гараар хутгыг барьж, зүүн гараар хамгаалж татах. | **2.** Эрхий хуруугаар хамгаалж ажиллах барилт. | **3.** Баруун гараар хутгыг барьж, зүүн гараар хамгаалж түлхэх. |








A.1-а, 2-б, 3-в, B. 1-в, 2-б, 3-а C. 1-б, 2-а, 3-в D.1-б, 2-в, 3-а

21. Модон материалаар зурагт үзүүлсэн бүтэн сийлбэр хийх технологийг зөв дараалалд оруулсан хариуг сонгоно уу.



1. Сийлэх дүрсийг уран хөрөөгөөр хөрөөдөж гаргах.
2. Нарийвчлан сийлбэрлэх, цэвэр зоролт хийх, дэл, сүүлийг самнах, нүд, чихийг сийлэх, өнгөлгөө хийх.
3. Нэвт цоолох хэсгүүдийг гарган, тэгш хэмтэйгээр ерөнхийлөн зорж сийлбэрлэх.
4. Модон бэлдцийг хэмжээний дагуу бэлтгэх.

A. 4-3-2-1 B. 4-1-2-3 C. 4-1-3-2 D. 4-3-1-2

22. Монгол дархны хөөмөл хийх технологийг зөв дараалалд оруулсан хариуг сонгоно уу.



1. Хөөмлийг сайтар өнгөлж ургамлын тос түрхээд бага зэрэг халааж харлуулна.
2. Хөөмлийг эргүүлж лаванд суулгаад дүрсийн ар талаас нь хөөлтүүр хэмээх багажаар цохиж хонхойлгон хэлбэрийг гаргана.
3. Металл дээр зургаа буулгаж зураасыг дагуулж хөөмлийн хавтгай толгойтой багажаар цааш нь тодолж цохино.
4. Хөөмлийн нүүрэн талыг дахин дээш харуулж лаванд суулгаад товгор хэсгийг засаж, дэвсгэр хэсгийг хөөмлийн шувтан үзүүртэй багажаар цоохорлоно.
5. Хөөмөл хийх 0.2-2 мм зузаан металлыг улайсгаж уяраагаад лаванд суулгана.

A. 5-3-2-4-1 B. 5-2-4-1-3 C. 5-4-2-1-3 D. 5-2-3-1-4

23. Машин нь хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, хурдасгах зориулалт бүхий энерги, материал, мэдээллийг хувирган өөрчлөх чадвартай техникийн төхөөрөмж юм. Ямар нэг мэдээллийг үүсгэх, хүлээн авах, дамжуулах, хадгалах зориулалттай машиныг сонгоно уу.
    A. мэдээллийн машин
    B. энергийн машин
    C. кибернетик машин
    D. ажлын машин
24. Хүний хөдөлмөр хөнгөвчилж материалын хэлбэр, хэмжээг өөрчлөх ажлын машины зургийг сонгоно уу.


A.


B.


C.


D.

25. Эд ангиудын кинематик тэмдэглэгээнүүдийг ашиглан дүрсэлсэн зургийг кинематик бүдүүвч гэнэ. Зурагт ямар суурь машины кинематик бүдүүвчийг үзүүлсэн бэ? Зөв хариуг сонгоно уу.




A. өрмийн суурь машин
B. точилын суурь машин
C. модны токарийн суурь машин
D. металлын токарийн суурь машин